




СОЁЛ УРЛАГ, ЧӨЛӨӨТ ЦАГ, БИЕЙН ТАМИР


Сонины тоо буурах хандлага 2012 оноос хойш тогтмол ажиглагдах болсон. 2017 онд нийслэлд 64 сонин дугаараа тогтмол гаргаж байсан нь өмнөх оныхоос 2-оор цөөрсөн байна¹. Энэ нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулсан нийт сонины 72.7 хувийг эзэлж байгаа юм. Өмнөх онтой харьцуулахад 10-14 хоног тутмын сонины тоо 3-аар, бусад ангилалын сонины тоо 1-ээр тус бүр нэмэгдсэн бол бусад бүх ангиллын сонины тоо буурчээ. Тухайлбал, 10-14 хоног тутмын “Налайхын амьдрал” сонин давтамжаа өөрчилснөөр тус ангилалын сонин 3-аар өссөн байна.

Гаралтын давтамжийн хувьд дугаар гаргасан гурван сонин тутмын нэг нь 10-14 хоногийн, таван сонин тутмын нэг нь 7 хоног болон сар тутмынх байгаа бол 14.1 хувийг өдөр тутмын, 4.7 хувийг 3-4 хоног тутмын сонин тус тус эзэлж байна.

Зураг 36. Сонины тоо, гаралтын давтамжаар



Зураг 37. Сонины тоо, борлуулалтын хэмжээ



Сонины борлуулалтын хэмжээ сүүлийн таван жил дараалан буурч, 2017 онд 13.3 сая ширхэг болжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулахад сонины нийт борлуулалт 4.9 хувиар буюу бараг 679 мянган тоо ширхэгээр буурсан үзүүлэлт юм. Сонины борлуулалтын зах зээлийн 77.6 хувийг өдөр тутмын сонин эзэлсэн хэвээр байна.

Хүснэгт 72. Сонины борлуулалт, мянган ширхэг


Гаралтын давтамж	2005	2010	2015	2016	2017
өдөр тутмын	14149.6	13958.4	13055.2	10438.4	10294.4
3-4 хоног тутмын	827.3	1210.0	1401.6	1084.8	739.2
7 хоног тутмын	9182.8	2392.6	1248.0	1234.8	1081.2
10-14 хоног тутмын	4263.6	1256.8	1122.8	857.2	900.7
сар тутмын	706.5	291.8	276.0	327.0	242.4
бусад	395.3	11.8	29.8	6.0	11.6
Нийт	29525.1	19121.4	17133.4	13948.2	13269.2

2017 онд нийслэл хотод байршин үйл ажиллагаа явуулж байсан 10 сэтгүүл хаагдаж, 1 сэтгүүл шинээр гарах болсоноор сэтгүүлийн тоо 71 болж өмнөх оныхоос есөөр буурав.


¹ Хэвлэлийн Хүрээлэн, “Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр” судалгааны тайлан, 2017 он

Нийт сэтгүүлийн дүнд улирал тутмын сэтгүүлийн тоо давамгайлж 42.5 хувийг эзлэх болсон нь өмнөх оноос 5.3 пунктээр өссөн үзүүлэлт юм. Гэхдээ 10-14 хоног тутмын болон 2 сар тутмын сэтгүүлээс бусад ангиллын сэтгүүлийн тоо 2016 онд буурсан байна.

Зураг 38. Сэтгүүлийн тоо, гаралтын давтамжаар



Зураг 39. Сэтгүүлийн тоо, борлуулалтын хэмжээ



2013 оноос эхлэн сэтгүүлийн борлуулалт тогтмол буурч байна. Энэ хандлага 2017 онд ч хэвээр үргэлжилж өмнөх онохоос 36.9 хувиар Харин 10-14 хоног тутмын сэтгүүлийн борлуулалт нэмэгдсэн байна. Дөрвөн сэтгүүл тутмын гурав нь нийт орон даяар түгээгдэж байна. Үүнд долоо хоног тутмын сэтгүүлийн тоо огцом буурсан нь илүүтэй нөлөөлсөн байна.

Хүснэгт 73. Сэтгүүлийн борлуулалт, мянган ширхэг

Гаралтын давтамж	2005	2010	2015	2016	2017
7 хоног тутмын	204.6	2981.1	2577.6	1340.4	768.0
10-14 хоног тутмын	237.7	161.5	184.2	199.2	247.2
сар тутмын	202.6	301.2	831.0	514.6	340.0
2 сар тутмын	22.4	107.0	24.6	25.5	14.4
улирал тутмын	90.6	196.8	81.0	48.3	30.8
бусад	22.0	0.2	12.2	5.4	0.5
Нийт	779.9	3747.8	3710.6	2223.4	1400.9

2010 оноос эхлэн сэтгүүлийн нийт борлуулалтад долоо хоног тутмын сэтгүүл 70-80 орчим хувийг эзэлж байв. Энэ байдал сүүлийн хоёр жилд өөрчлөгдөж, 2017 онд 54.8 хувь болтлоо буурсан нь өмнөх оноос 10.1 пунктээр, 2010 оноос 24.7 пунктээр тус тус доогуур байгаа юм.

2017 онд нийслэл хотод 3.2 сая гаруй ширхэг номын фондтой, нийт 1446 суудал бүхий уншлагын танхимтай 12 нийтийн номын сан ажилласан байна. Эдгээрийн 2 нь төрийн өмчийн, 10 нь орон нутгийн өмчийнх юм.

2017 онд нийтдээ 269.4 мянган хүнд 579.4 мянган ширхэг ном олгож үйлчилжээ. Уншигчдад олгосон нийт номын 88.6 хувийг нь уншлагын танхимд, 9.8 хувийг гэрээр, 1.6 хувийг зөөврөөр олгосон байна. Номын сангийн байнгын уншигчдын тоо 24.5 мянга болж өмнөх 2016 оноос 1.2 мянган хүнээр (4.7%) буурсан байна.

Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй 23 музейд дэлгэн тавьсан нийт үзмэрийн тоо 145.6 мянга болж, 219.7 мянган үзэгчдийн хүртээл болсон байна. Эдгээр музейн 13 нь төрийн өмчийнх байгаа бол орон нутгийн өмчийн 3 хувийн болон өмчийн бусад хэлбэрийн 3 музей байна.

Хүснэгт 74. Музейн үзмэр, үзэгчдийн тоо

Музейн нэр	Үзмэрийн тоо				Үзэгчид, мянган хүн			
	2010	2015	2016	2017	2010	2015	2016	2017
Бүгд	135 729	140 396	151 051	145 645	209.6	256.1	219.7	219.7
Үүнээс:								
Байгалийн түүхийн музей	14 311	10 357	11 347	11 915	63.0	-	-	-
Үндэсний түүхийн музей	50 442	56 597	58 554	59 192	47.2	62.7	67.7	85.3
Дүрслэх урлагийн музей	17 422	16 585	16 585	16 809	21.0	19.0	7.6	9.3
Богд хааны ордон музей	8 742	8 636	8 636	8 639	25.1	31.9	35.0	41.3
Чойжин ламын сүм музей	6 208	6 376	6 376	6 385	13.8	16.5	13.4	9.0
Монголын театрын музей	9 338	9 494	9 494	9 494	2.0	2.9	2.1	1.6
Уран зургийн галерей	3 700	3 772	4 135	4 140	4.5	10.0	4.6	8.3
Монгол цэргийн музей	8 642	9 752	9 300	9 382	10.0	6.9	8.7	7.5
Улсын хилийн музей	3 455	3 455	3 455	3 167	2.6	2.6	-	7.2
Монгол төрийн түүхийн музей	692	1 218	1 081	1 172	-	68.0	25.5	1.8
Үлэг гүрвэлийн музей	-	22	31	41	-	20.6	40.0	38.9
Олон улсын оюун ухааны музей	9 228	10 256	9 155	9 646	11.7	9.1	8.2	9.5
Улаанбаатар хотын музей	3 339	3 876	3 358	-	6.7	5.9	2.5	-

Үзмэрийн тоогоор Үндэсний түүхийн музей тэргүүлсэн хэвээр байна. 2017 онд тус музейд 638 үзмэр шинээр нэмэгдэж, нийтдээ 59.2 мянган үзмэртэй болжээ. Байгалийн түүхийн музей сүүлийн 3 жилд нийтэд үйлчлэх боломжгүй байгаа хэдий ч 568 үзмэрийг шинээр бий болгосон нь 2017 онд нэмэгдсэн нийт үзмэрийн 20.0 хувийг эзэлж байна.

2017 онд Үндэсний түүхийн музейг 85.3 мянган хүн (38.8%) үзэж сонирхсон нь улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Музейн үзэгчдийн 62.9 мянга нь хүүхдүүд байв. Энэ нь музейд зочилсон гурван хүн тутмын нэг нь хүүхдүүд байжээ гэсэн үг юм.

2017 онд манай оронд зочилсон гадаадын 104.6 мянган жуулчид нийслэлд байрлах музейнүүдийг үзэж сонирхсон нь өмнөх оноос 9.1 мянган жуулчдаар илүү буюу 9.5 хувиар өсчээ. Өөрөөр хэлбэл, музейн үзэгчдийн 44.7 хувийг гадаадын иргэд эзэлж байв.

Музейд зочилсон гадаадын иргэд, жуулчдын 52.1 мянга (49.8%) нь Үндэсний түүхийн музейг, 5.5 мянга (5.2%) гаруй нь Богд хааны ордон музейг, 3.5 мянга (3.3%) нь Чойжин ламын сүм музейг, 18.2 мянга (17.4%) нь Үлэг гүрвэлийн музейг үзжээ.

Хүснэгт 75. Мэргэжлийн урлагийн байгууллагын суудал, тоглолтын тоо, үзэгчид

Мэргэжлийн урлагийн байгууллагын нэр	Суудлын тоо	Тоглолтын тоо				Үзэгчид, мянган хүн			
		2010	2015	2016	2017	2010	2015	2016	2017
Бүгд	6 505	2026	1 479	2 530	1 729	351.0	3511.0 ²	827.2	1 477.9
Үүнээс:									
Улсын дуурь бүжгийн эрдмийн театр	500	85	92	96	95	30.6	37.1	50.0	38.5
Улсын драмын эрдмийн театр	594	214	189	114	197	35.4	62.0	48.0	63.4
Үндэсний урлагийн их театр	565	201	139	304	339	19.8	38.2	24.5	32.5
Улсын филормони	260	138	46	133	146	17.1	17.4	58.8	67.4
Улсын хүүхэлдэйн театр	166	145	80	92	98	8.0	25.6	11.0	9.0
Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулга	370	300	236	254	284	-	66.8	68.8	93.3
Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулга	340	227	154	197	103	-	21.0	23.0	35.4
АСА цирк	2 200	42	42	25	29	181.0	104.4	32.0	32.5
“Сарны чулуу” чуулга	-	40	-	9	6	22.0	-	0.1	108
“Түмэн-Эх” чуулга	280	280	300	304	339	18.5	23.0	24.5	32 500
“Улаанбаатар” чуулга	830	246	170	202	263	-	3 109.1	12.7	1 071.4
Төмөр замчдын дуу, бүжгийн чуулга	400	108	31	15	3	18.6	6.5	12.0	1 080

2017 онд мэргэжлийн урлагийн байгууллагуудаас нийт 1729 удаагийн тоглолт хийж, давхардсан тоогоор 1477.9 мянган үзэгчдэд үйлчилжээ. Мэргэжлийн урлагийн байгууллагуудын нийт тоглолтын 19.7 хувийг хүүхдэд зориулсан тоглолт эзэлж, 50.9 мянган хүүхэд багачуудад урлагийн тоглолт, үзвэрээр үйлчилжээ. Хүүхдэд зориулсан нийт тоглолтын 12.4 хувийг Улсын Хүүхэлдэйн Театр, 38.7 хувийг Улсын Драмын Эрдмийн Театр зохион байгуулсан байна. Мэргэжлийн урлагийн байгууллагуудын урын санд нийтдээ 4369 уран бүтээл бүртгэлтэй байна.


2017 онд мэргэжлийн урлагийн байгууллагууд шинээр 85 уран бүтээл туурвисан нь улсын хэмжээнд туурвисан нийт шинэ уран бүтээлийн 62.0 хувийг эзэлж байгаа ажээ.

Зураг 40. Кино театр, үзэгчдийн тоо

2017 онд нийслэл хотод 5887 суудалтай 5 кино театр үйл ажиллагаа явуулж, нийтдээ 64319 удаагийн кино гаргалтаар 1175.1 мянган үзэгчдэд үйлчилж, 18.2 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Нийт орлогынх нь 39.7 хувийг кино үзвэрийн орлого бүрдүүлжээ.

Нийт үзэгчдийн 52.2 хувь нь Тэнгис кино театраар, 4.9 хувь нь Соёмбо, 15.1 хувь нь



Хүннү молл, 18.5 хувь нь Гэгээнтэн интертаймент, 9.3 хувь нь Өргөө кино театраар үйлчлүүлжээ.

2017 онд 18.2 мянга гаруй суудалтай 17 соёлын төв (ордон) нийслэлийн иргэд, оршин суугчдад жилийн турш үйлчилж, 2550 арга хэмжээ зохион байгуулсан байна. Эдгээр арга хэмжээний 42.9 хувийг соёл урлагийн, 57.1 хувийг нь дугуйлан болон бусад арга хэмжээ эзэлж байгаа юм.

Нийслэл хотод жилийн турш 272 спортын заал, танхим ажиллаж, нийслэл хотын аварга шалгаруулах тэмцээнийг 26 төрлөөр зохион байгуулж, 4.4 мянган тамирчид оролцсон байна.

Хүснэгт 77. Биеийн тамир, спортын зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2005	2010	2015	2016	2017
Спортын заал, танхим, бүгд	169	308	265	259	272
Үүнээс: Спортын заал	-	135	218	212	272
Нийслэл хотын аварга шалгаруулах тэмцээн	30	72	23	17	26
Тэмцээнд оролцсон тамирчид, мянган хүн	18.6	42.0	4.1	3.2	4.4
Бүх нийтийг хамарсан өдөрлөг, аялал, чийрэгжилтийн арга хэмжээ	16	50	463	442	510
Үүнд хамрагдсан хүн, мянган хүн	128.1	278.1	607.1	673.5	710.0
Баяр ёслол, тэмдэглэлт ой, нэрэмжит тэмцээн	-	112	44	41	38

2017 онд бүх нийтийг хамарсан аялал, өдөрлөг, чийрэгжилтийн арга хэмжээг 510 удаа зохион байгуулж, түүнд давхардсан тоогоор 710.0 мянган хүн оролцжээ. Тухайлбал, нийслэлийн иргэдийн спортын наадмыг 7 төрөл /спорт явган аялал, ширээний шагай, хийн дасгал, аэробек, олс таталт, гар бөмбөг, сагсан бөмбөг/-өөр, хэсэг, хороо, бүс, дүүрэг, нийслэл гэсэн 5 үе шаттайгаар зохион байгуулж, нийт 90 мянган иргэд оролцсон байна.

Мөн түүнчлэн “Улаанбаатар марафон-2017” олон улсын гүйлтийг 6 зайн төрөлд зохион байгуулж, 36.8 мянга гаруй хүн оролцсон байна.